



НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/189

Улаанбаатар хот

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссыг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг, Засгийн газрын 2021 оны “Дүрэм шинэчлэн батлах тухай” 173 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.0-16 насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих зорилго бүхий дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын Салбар комиссыг шинэчлэн байгуулсугай.

2.Салбар комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, салбар комиссын гишүүдтэй “Хөлсөөр ажиллах гэрээ”-г байгуулж, хууль, тогтоомжийн хүрээнд үйл ажиллагааг зохион байгуулахыг Салбар комисс (С.Мөнхзаяа)-т, салбар комиссын шийдвэрийг үндэслэн холбогдох арга хэмжээг шуурхай авч ажиллахыг Эрүүл мэндийн төв, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Боловсролын хэлтэст тус тус үүрэг болгосугай.

4.Энэ захирамж гарсантай холбогдуулан “Салбар комисс шинэчлэн байгуулах тухай” дүүргийн Засаг даргын 2021 оны А/126 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.СУМЪЯАБААТАР

Баянгол дүүргийн Засаг даргын
2022 оны 05 дугаар сарын 16-ний өдрийн
148 дугаар захирамжийн хавсралт



**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН
ЭРҮҮЛ МЭНД, БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЛБАР САЛБАР КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН**

Салбар комиссын дарга:	С.Мөнхзаяа	(Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга)
Нарийн бичгийн дарга:	Э.Солонго	(Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал хариуцсан мэргэжилтэн)
Гишүүд:		
Боловсролын ажилтан	Г.Баялагмаа	(Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн Боловсролын асуудал хариуцсан мэргэжилтэн)
Нийгмийн ажилтан	Б.Мөнхбат	(Засаг даргын Тамгын газрын Хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн)
Хүүхдийн эмч	Д.Бямбадалай	(Хүүхдийн ерөнхий зохицуулагч, эмч)
Мэдрэлийн эмч	Э.Алтанзаяа	(Эрүүл мэндийн төвийн мэдрэлийн эмч)
Төрийн бус байгууллагын төлөөлөл	Г.Цэен	(“Энэрлийн түүчээ” ТББ-ын төлөөлөл)